



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/46

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын  
135 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын 135 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,042,264.44 (таван сая дөчин хоёр мянга хоёр зуун жаран дөрвөн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 135 дугаар сургууль (П.Энхбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500239

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Ерөнхий боловсролын 135 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жиг	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан үндэс	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын агын санал	ҮХХХК-ын шийдвэр
1	Ном, сурах бичиг	5	Ш	3136	-	5,042,264.44	-	-	Хичээлийн хөтөлбөр өөрчлөгдсөн. Эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон.	Данснаас хасах	Данснаас хасах	Данснаас хасах
Нийт дүн						5,042,264.44	-	-				